



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар A/65


Бор-Өндөр сум

**Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлж,
Гамшгийн аюулын зарлан мэдээллийн
дохиогоор ажиллах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 339, 2017 оны 67 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт сумын хэмжээнд зохион байгуулсугай.
2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг өндөр түвшинд зохион байгуулахыг нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд үүрэг болгосугай.
3. Хийгдэх ажлын төлөвлөгөөг төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
4. Арга хэмжээнд шаардагдах 885,000 /найман зуун наян таван мянга/-н төгрөгийг гамшгийн эрсдэлийн сангийн хөрөнгөөс гаргахыг Санхүү албаны дарга /Э.Түвшинсайхан/-д зөвшөөрсүгэй.
5. Мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Бор-Өндөр сум дахь Онцгой байдлын хэлтсийн дарга /дэд хурандаа Г.Мөнхнаран/-д даалгасугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ